САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТЭНХИМ

Хун
Батчулуу АНУЖИН

УГААЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХИАЛГА ХҮРГЭЛТИЙН СИСТЕМ ("LaundryZone Mongolia"-компанийн жишээн дээр)

Мэргэжлийн индекс
061303

Мэдээллийн системийн бакалаврын
Зэрэг горилсон
Дипломын төсөл

Удирдсан
Г.Эрдэнэцэцэг/MBA/

Улаанбаатар. 2026

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТЭНХИМ

Хун
Батчулуу АНУЖИН

УГААЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХИАЛГА ХҮРГЭЛТИЙН СИСТЕМ
(“LaundryZone Mongolia”-компанийн жишээн дээр)

Мэргэжлийн индекс
061303

Мэдээллийн Системийн Бакалаврын Зэрэг
Горилсон Дипломын Төсөл

Удирдагч : . . . . . Г.Эрдэнэцэцэг \MBA\

Зөвлөх : . . . . . Г.Эрдэнэцэцэг MBA\

Шүүмж : . . . . . Ц. Гүндэгмаа \MBA\

Улаанбаатар. 2026

ГАРЧГИЙН ТОВЪЁГ

МЭДЭГДЭЛ i
ТАЛАРХАЛ ii
ТОВЧ ХУРААНГУЙ iii
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ v
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ vi
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР vii
ОРШИЛ 1
Судалгааны зорилго 1
Судалгааны зорилтууд 2
Хамрах хүрээ 2
Судалгааны объект 2
Судалгааны арга зүй 2
I БҮЛЭГ. ОНОЛЫН СУУРЬ СУДАЛГАА 4
1.1 Угаалгын үйлчилгээ 5
1.2 Угаалгын үйлчилгээ, түүний төрлүүд 6
1.3 Угаалгын үйлчилгээний захиалга, хүргэлтийн систем 8
1.3.1 Захиалгын удирдлагын систем 8
1.3.1.3 Захиалгын удирдлагын систем-ийн ач холбогдол 9
1.4 Сэдвийн судлагдсан байдал 10
II БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГА БА АСУУДЛЫН ШИНЖИЛГЭЭ 16
2.1 Компаний танилцуулга 16
2.2 “LaundryZone Mongolia ”угаалгын үйлчилгээний AS-IS процесс 19
2.3 Асуудлын шинжилгээ 20
2.3.1 PIECES шинжилгээ 20
2.4 “LaundryZone Mongolia ”угаалгын үйлчилгээний TO-BE процесс 23
III БҮЛЭГ. СИСТЕМИЙН ШИНЖИЛГЭЭ 25
3.1 Судалгааны үр дүн (Хавсралт 3 1 Хэрэглэгчийн судалгаа) 25
3.2 Ижил төстэй системийн судалгаа 27
3.3 Feature analysys 30
3.4 Context Диаграм 33
3.5 Use Case Диаграм ба Тодорхойлолт 34
3.5.1 Системийн Actors (Оролцогч талууд) 34
3.5.2 Use Case-ийн тодорхойлолт 35
3.5.3 Дэлгэрэнгүй Use Case тодорхойлолт 36
3.6 Функциональ Шаардлага 37

3.6.1 Хэрэглэгчийн удирдлагын модуль....37
3.6.2 Захиалгын удирдлагын модуль....38
3.6.3 Төлбөрийн модуль....38
3.6.4 Хүргэлтийн удирдлагын модуль....39
3.6.5 Мэдэгдэл ба Харилцааны модуль....40
3.6.6 Менежрийн модуль....40
3.7 Функциональ Бус Шаардлага....40
3.8 Өгөгдлийн сангийн бүтэц....42
3.9 Хэрэглэгч систем хоорондын Activity diagram....43
3.10 Угаалгын ажилтан болон ажилтны систем Activity diagram....44
3.11 Захиалга өгөх Sequence diagram....45
3.12 UI&UX design....46
3.13 Байгууллагын вэб....54
ДҮГНЭЛТ....67
САНАЛ ЗӨВЛӨМЖ....69
НОМ ЗҮЙ....70
ХАВСРАЛТ....72

МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна.Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа,ашгийн бус зорилгоор, зохиогчинй эрхийн зөрчлөөс сэргийлэх үүндээс олон улсын Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivs (CC BY-NC-ND) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Нэр : Б.Анужин

Гарын үсэг: Анужин

Огноо:2026.03.20

ТАЛАРХАЛ

Энэхүү дипломын төслийн ажлыг хийж гүйцэтгэхэд туслалцаа үзүүлж, мэргэжлийн зөвлөгөө, чиглэл өгөн харамгүй сэтгэлээр дэмжсэн удирдагч багш СЭЗИС-ийн Мэдээллийн системийн менежментийн тэнхимийн багш Г.Эрдэнэцэцэг танд мөн энэхүү дөрвөн жилийн хугацаанд туслаж дэмжиж байсан гэр бүл, найз нөхөд, бүх багш нартаа гүн талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Монгол Улсад хотжилт эрчимтэй нэмэгдэж, хүн амын төвлөрөл хот суурин газруудад ихсэхийн хэрээр ахуйн үйлчилгээний эрэлт, тэр дундаа угаалгын үйлчилгээний хэрэглээ жилээс жилд өсөн нэмэгдэж байна *(Num.edu.mn, n.d.)*Хотын амьдралын хурдац, цаг хугацааны хомсдол нь иргэдийг гадны үйлчилгээ, ялангуяа угаалгын үйлчилгээ ашиглах хандлагыг нэмэгдүүлж байна.

Гэсэн хэдий ч ихэнх угаалгын үйлчилгээ эрхлэгч байгууллагууд захиалгаа уламжлалт аргаар, тухайлбал утсаар, сошиал сүлжээний чат ашиглан эсвэл биечлэн хүлээн авч байгаа нь үйлчилгээний үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Энэ нь захиалгын мэдээлэл алдагдах, давхцах, буруу бүртгэгдэх, мөн хүргэлтийн үйл ажиллагааны зохион байгуулалт алдагдах зэрэг асуудлуудыг үүсгэж байна *(Review Paper)*

Иймд энэхүү дипломын ажил нь угаалгын үйлчилгээний онлайн захиалга, хүргэлтийн системийг шинжлэх, зохиомжлох замаар үйлчилгээг цахимжуулах, автоматжуулах боломжийг судалсан болно.Судалгаанд чанарын (ажиглалт, судалгааны) болон асуулгын аргыг хослуулан ашиглаж, Улаанбаатар хотын угаалгын үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдалын судалгаа хийсэн.

Судалгааны үр дүнд боловсруулсан систем нь хэрэглэгчийн захиалгыг онлайн хэлбэрээр хүлээн авч, хүргэлтийн үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, автоматжуулах боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр үйлчилгээний хурд, чанар сайжирч, хэрэглэгчийн сэтгэл ханамж нэмэгдэхээс гадна байгууллагын өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих цогц шийдэл бий болно.

Энэхүү системийг нэвтрүүлснээр захиалгын удирдлага сайжирч, хүргэлтийн үр ашиг нэмэгдэн, үйл ажиллагааны зардал буурч, бизнесийн өрсөлдөх чадвар дээшлэх бүрэн боломжтой юм.

Түлхүүр үгс: *угаалгын үйлчилгээ, онлайн захиалгын систем, хүргэлтийн систем, мэдээллийн систем, автоматжуулалт, функциональ шаардлага, үр ашиг , функциональ бус шаардлага.*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 Сэдвийн судлагдсан байдал 11
Хүснэгт 2.1 PIECES шинжилгээ 19
Хүснэгт 2.2 Асуудал тодорхойдох матриц 20
Хүснэгт 3.1 Ижил төстэй системийн судалгаа 26
Хүснэгт 3.2 Feature analysys 29
Хүснэгт 3.3 Системийн оролцогч талууд 32
Хүснэгт 3.4 Дэлгэрэнгүй Use Case тодорхойлолт 34
Хүснэгт 3.5 Хэрэглэгчийн удирдлагын модуль 35
Хүснэгт 3.6 Захиалгын удирдлагын модуль 36
Хүснэгт 3.7 Төлбөрийн модуль 36
Хүснэгт 3.8 Хүргэлтийн удирдлагын модуль 37
Хүснэгт 3.9 Мэдэгдэл ба харилцааны модуль 38
Хүснэгт 3.10 Менежрийн модуль 38
Хүснэгт 3.11 Функциональ Бус Шаардлага 39

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1 AS-IS process 19
Зураг 2.2 TO-IS process 23
Зураг 3.1 Судалгааны асуулга 1 25
Зураг 3.2 Судалгааны асуулга 2 25
Зураг 3.3 Судалгааны асуулга 3 26
Зураг 3.4 Судалгааны асуулга 4 26
Зураг 3.5 Context Diagram 33
Зураг 3.6 Use Case тодорхойлолт 35
Зураг 3.6 Өгөгдлийн сангийн бүтэц 42
Зураг 3.7 Хэрэглэгч систем хоорондын Activity diagram 43
Зураг 3.7 Угаалгын ажилтан болон ажилтны систем Activity diagram 44
Зураг 3.8 Захиалга өгөх Sequence diagram 45
Зураг 3.9 Хэрэглэгчийн UI&UX design 1 46
Зураг 3.10 Хэрэглэгчийн UI&UX design 2 47
Зураг 3.11 Хэрэглэгчийн UI&UX design 3 48
Зураг 3.12 Хэрэглэгчийн UI&UX design 4 49
Зураг 3.13 Хэрэглэгчийн UI&UX design 5 50
Зураг 3.14 Хэрэглэгчийн UI&UX design 6 51
Зураг 3.15 Хэрэглэгчийн UI&UX design 7 52
Зураг 3.16 Хэрэглэгчийн UI&UX design 8 53
Зураг 3.17 Байгууллагын UI&UX design 1 54
Зураг 3.18 Байгууллагын UI&UX design 2 55
Зураг 3.19 Байгууллагын UI&UX design 3 56
Зураг 3.20 Байгууллагын UI&UX design 4 57
Зураг 3.21 Байгууллагын UI&UX design 5 58
Зураг 3.22 Байгууллагын UI&UX design 6 59
Зураг 3.23 Байгууллагын UI&UX design 7 60
Зураг 3.24 Байгууллагын UI&UX design 8 61
Зураг 3.25 Байгууллагын UI&UX design 9 62
Зураг 3.26 Байгууллагын UI&UX design 10 63
Зураг 3.27 Байгууллагын UI&UX design 11 64
Зураг 3.28 Байгууллагын UI&UX design 12 65
Зураг 3.29 Байгууллагын UI&UX design 13 66

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт А Байгууллагын тоног төхөөрөмж 72
Хавсралт В Угаалгын газрын салбарын тойм 75
Хавсралт С Хэрэглэгчийн судалгаа 79

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Нэршил	Тайлбар
Угаалгын үйлчилгээний захиалг хүргэлтийн систем	Хүргэлтийн систем гэсэн нэршилээр цаашид дуудагдаж явна.
AS-IS процесс	Байгууллагын одоогийн үйл ажиллагааны процесс.
TO-BE процесс	Сайжруулсан, шинэ байдлын процесс.
PIECES шинжилгээ	Performance, Information, Economics, Control, Efficiency, Service гэсэн 6 үзүүлэлтээр системийн асуудлыг шинжлэх арга.
OMS (Order Management System)	Захиалгын удирдлагын систем; захиалгыг эхнээс төгсгөл хүртэл удирдах иж бүрэн систем.
Use Case диаграм	Системийн хэрэглэгчид болон функцуудын хоорондын харилцааг харуулсан загвар.
Context диаграм	Системийн хамрах хүрээ болон гадаад оролцогч талуудтай харилцах өгөгдлийн урсгалыг харуулсан загвар.
Actor	Системийн оролцогч тал (хэрэглэгч, ажилтан, менежер г.м).
ERD (Entity Relationship Diagram)	Өгөгдлийн сангийн бүтэц, хүснэгтүүдийн хоорондын холбоог харуулсан загвар
Activity diagram	Үйл ажиллагааны урсгал, дарааллыг харуулсан UML загвар.
Sequence diagram	Системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын харилцааны дарааллыг харуулсан загвар
Heuristic үнэлгээ	Ашиглахад хялбар байдлыг 10 зарчмаар үнэлэх UI/UX шинжилгээний арга.
Real-time tracking	Захиалга эсвэл хүргэлтийн байршлыг бодит цаг хугацаанд хянах боломж.
Push notification	Гар утасны аппликейшнээр шууд илгээгддэг мэдэгдэл.
OTP (One-Time Password)	Нэг удаагийн баталгаажуулах код.

ОРШИЛ

Улаанбаатар хотод завгүй амьдралын хэв маяг, цаг хэмнэх хэрэгцээ нэмэгдсэн нь хэрэглэгчдийг хүргэлттэй угаалгын үйлчилгээг сонгох хандлагатай болгож байна *(Num.edu.mn, n.d.).*Гэвч одоогийн байдлаар угаалгын үйлчилгээ эрхэлдэг ихэнх байгууллагууд захиалгаа утас, сошиал чат (Facebook, Messenger) зэрэг уламжлалт сувгаар авч байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Судалгаанаас харахад захиалгын мэдээлэл гараар бүртгэгддэг, хүргэлтийн төлөвлөлт системгүй явагддаг, хэрэглэгчид үйлчилгээ авахад их цаг зарцуулдаг зэрэг нийтлэг асуудлууд ажиглагдсан. *Эх сурвалж:(Review Paper)*

Үүний улмаас:

- Угаалгын үйлчилгээний газруудын хэрэглэгчийн нэгдсэн мэдээллийн систем байхгүй
- Хүргэлт хийдэг газар одоогоор Монголд байхгүй
- Заавал биеэр очиж үйлчилгээ авдаг
- Хотын түгжрэл нь цаг алдах алдагдсан боломжийн зардал их үүсдэг
- Гэртээ угаах боломжгүй тохиолдолд заавал цаг зарцуулах зэрэг хүндрэлүүд үүсдэг
- Байгууллага талдаа зарим үед хэт ачаалал болон сул зогсолт бий болдог

Нөгөө талаас, Монголд хүргэлтийн үйлчилгээ хурдацтай хөгжиж байгаа нь хэрэглэгчид онлайн захиалга, real-time мэдээлэл авахад дассан байгааг харуулж байна. *(Num.edu.mn, Num.edu.mn, n.d.)* Гэсэн хэдий ч угаалгын үйлчилгээний салбарт хэрэглэгч төвтэй, дижитал шийдэл хангалттай хөгжөөгүй байна. Иймд энэхүү дипломын ажил нь угаалгын үйлчилгээний онлайн захиалга, хүргэлтийн шинэ системийн зохиомж-ийг хэрэглэгчийн хэрэгцээнд тулгуурлан тодорхойлох, загварчлахад чиглэнэ.

Судалгааны зорилго

Laundry Zone компанийн үйл ажиллагаанд зориулсан онлайн захиалга хүргэлтийн үйлчилгээний системийн шинжилгээ ба зохиомжийг боловсруулахад оршино.

Судалгааны зорилтууд

- Зах зээл болон хэрэглэгчийн хэрэгцээг судлах
- Байгууллагын одоогийн үйл ажиллагааг судалж асуудлыг тодорхойлох
- Ижил төстэй бүтээгдэхүүн (apps, platforms)-ийн судалгаа хийнэ
- Судалгаа хийсний үндсэн дээр системийн шинжилгээ зохиомжийг хийх
- Прототайпын эхний хувилбар гаргана

Хамрах хүрээ

- Бүтэн системийн хөгжүүлэлт хийгдэхгүй

Судалгааны объект

“LaundryZone Mongolia”

Хүлээгдэж буй үр өгөөж

- Хэрэглэгч гар утсаар угаалгын үйлчилгээний захиалж хүргэлтээр авах боломжтой болно
- Хүлээлгийн хугацаа багасна
- Өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт боломжтой болно
- Шинэ хэрэглэгч татах, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ
- Байгууллагын үр ашигтай байдал нэмэгдэнэ

Судалгааны арга зүй

Энэхүү дипломын ажлын хүрээнд угаалгын үйлчилгээний захиалга, хүргэлтийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор мэдээллийн системийн шинжилгээ, зохиомжийг боловсруулна. Судалгааны ажлын хүрээнд хэрэглэгчийн хэрэгцээ, зан төлөв, үйлчилгээ авахад тулгарч буй хүндрэлүүдийг тодорхойлохын зэрэгцээ байгууллагын одоогийн үйл ажиллагаа, бизнес процессын сул талуудыг судална. Мөн одоогийн процессын үр ашиггүй байдал, доголдлыг тодорхойлон, сайжруулсан бизнес процессын загварыг боловсруулна. Үүний үндсэн дээр системийн функциональ болон функциональ бус

шаардлагуудыг тодорхойлж, хэрэглэгчийн туршлага (UX)-ыг харгалзан системийн зохиомжийг боловсруулна.

Судалгааны аргууд

1. Ажиглалтын арга LaundryZone угаалгын үйлчилгээний байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг ажиглаж, захиалга авах, боловсруулах, хүргэлт зохион байгуулах зэрэг бизнес процессын үе шатуудад тулгарч буй хүндрэл, сул талуудыг судална. Мөн хэрэглэгч үйлчилгээ авах явцад тулгарч буй асуудал, үйлчилгээний хурд, мэдээллийн хүртээмж, байгууллага болон хэрэглэгчийн хоорондын харилцааг ажиглан шинжилнэ.

2. Судалгааны арга нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход чиглэгдэнэ. Google Forms ашиглан хэрэглэгчдээс онлайн асуулга авч, үйлчилгээний чанар, захиалга өгөхөд тулгардаг бэрхшээл, захиалгын хялбар байдал, real-time мэдээллийн хэрэгцээ, хэрэглэгчийн сэтгэл ханамж зэрэг мэдээллийг цуглуулна. Судалгааны үр дүнд үндэслэн хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн, системд зайлшгүй шаардлагатай функцуудыг тодорхойлно.

I БҮЛЭГ. ОНОЛЫН СУУРЬ СУДАЛГАА

Энэхүү бүлэгт угаалгын үйлчилгээний захиалга, хүргэлтийн системийг хөгжүүлэхэд шаардлагатай онолын суурь ойлголтуудыг авч үзнэ. Орчин үеийн үйлчилгээний салбар нь уламжлалт үйл ажиллагаанаас илүүтэйгээр мэдээллийн технологид суурилсан, хэрэглэгч төвтэй хэлбэрт шилжиж байна. Үүний үр дүнд угаалгын үйлчилгээний салбарт онлайн захиалга, хүргэлт, real-time мэдээлэл зэрэг технологийн шийдлүүдийг ашиглан үйлчилгээг илүү хурдан, хялбар, хүртээмжтэй болгох шаардлага нэмэгдэж байна. *Эх сурвалж: (GlobalNewsWire, 2025)*

Бүлгийн хүрээнд угаалгын үйлчилгээний үйл ажиллагааны үндсэн ойлголт, онцлог шинж чанар, үйлчилгээний төрөл, процессын үе шат бүрийг онолын үүднээс тайлбарлана. Мөн онлайн захиалга, хүргэлтийн системийн бүтэц, ажиллагааны зарчим, үйлчилгээний чанарт үзүүлэх нөлөөллийг авч үзнэ.

Угаалгын үйлчилгээний салбарын онцлог, үйлчилгээний процесс, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагыг гүнзгий ойлгох нь дижитал бүтээгдэхүүн, систем боловсруулахад чухал ач холбогдолтой. Ялангуяа хэрэглэгчийн туршлага (UX), үйлчилгээний хүртээмж, хурд, найдвартай байдлыг сайжруулахад эдгээр хүчин зүйлс шууд нөлөөлдөг. *Эх сурвалж: (ResearchGate, n.d.)*

Орчин үеийн хэрэглэгчдийн зан төлөв эрс өөрчлөгдөж, цаг хэмнэх, хялбар, түргэн үйлчилгээ авах эрэлт нэмэгдэж байгаа нь онлайн захиалга болон хүргэлтийн үйлчилгээний хэрэглээг огцом өсгөж байна. Дижитал технологийн хөгжил, ухаалаг гар утасны хэрэглээ, интернэт орчны хүртээмж нэмэгдсэн нь үйлчилгээний салбарт шинэ боломжуудыг бий болгож, бизнесүүдийг улам бүр дижитал хэлбэрт шилжихэд хүргэж байна. *Эх сурвалж: (View, 2025)*

Ийм нөхцөл байдлыг харгалзан үзэж, угаалгын үйлчилгээний захиалга, хүргэлтийн системийг хөгжүүлэх онолын үндэслэл, шаардлага, ач холбогдлыг тодорхойлохыг энэхүү бүлгийн гол зорилго болгон авч үзэж байна.

Монгол улсад угаалгын үйлчилгээ нь орчин үеийн хэлбэрээрээ 1990-ээд оны зах зээлийн эдийн засгийн шилжилтийн дараагаас эрчимтэй хөгжиж эхэлсэн гэж үздэг. Энэхүү үйлчилгээний хөгжил нь нийгэм, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт, хотжилт, хүн амын амьдралын хэв маягийн хувьсалтай нягт холбоотой.Социализмын үед угаалгын үйлчилгээ нь төрийн өмчит ахуйн үйлчилгээний комбинатуудын хүрээнд зохион

байгуулагддаг байсан. Тухайн үед уг үйлчилгээ нь голчлон зочид буудал, эмнэлэг болон албан байгууллагуудад чиглэж байсан. Харин өрхийн түвшинд иргэд хувцсаа ихэвчлэн гараар угаах нь түгээмэл байсан бөгөөд хувийн хэвшлийн оролцоо бараг байгаагүй.1990 оноос хойш зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр хувийн хэвшил үүсч, угаалгын үйлчилгээний салбарт анхны жижиг бизнесүүд бий болсон. Энэ үед байгуулагдсан угаалгын газруудын тоног төхөөрөмж хязгаарлагдмал, үйлчилгээний төрөл харьцангуй энгийн байсан бөгөөд ихэвчлэн оюутнууд болон түрээсийн байранд амьдардаг иргэд үйлчлүүлдэг байв. *(Нийтийн аж ахуйн салбарын түүхэн товчоон, n.d.)*Тус салбар нь энэ үед суурь хөгжлийн шатандаа байсан гэж үзэж болно Харин 2005 оноос хойш Монгол Улсад хотжилт эрчимжиж, хүн амын төвлөрөл нэмэгдсэнээр угаалгын үйлчилгээний эрэлт мэдэгдэхүйц өссөн. Үүнтэй зэрэгцэн үйлчилгээний төрөл, хэлбэрүүд өргөжин хөгжсөн бөгөөд үүнд:

- Хими цэвэрлэгээ
- Өөрөө үйлчлэх угаалга
- Гутал пүүз угаах үйлчилгээ
- Дэвсгэр даавуу том зүйлс угаах үйлчилгээ зэрэг бага багаар ахицтай хөгжиж эхэлсэн *Эх сурвалж:(Нийтийн аж ахуйн салбарын түүхэн товчоон, n.d.)*

Мөн сүүлийн үед дижитал технологийн хөгжилтэй уялдан аппликейшн болон онлайн захиалгын системүүд гадаад улсуудад нэвтэрч эхэлснээр зарим хувийн хэвшлийн газрууд хүргэлтийн системгүй ч өөрсдийн боломжтой уялдуудан хүргэлт хийдэг болсон. Ялангуяа Улаанбаатар хотод энэхүү салбар нь хурдацтай хөгжиж буй ахуйн үйлчилгээний нэг болж байна. *Эх сурвалж: (GloabalNewsWire, n.d.)*

1.1 Угаалгын үйлчилгээ

Угаалгын үйлчилгээ нь хувцас, нэхмэл эдлэл болон ахуйн хэрэглээний даавуун бүтээгдэхүүнийг цэвэрлэх, угаах, хатаах, индүүдэх, ариутгах, эвхэх, хадгалах, мөн хүргэлтийн үйлчилгээ үзүүлэх зэрэг тухайн бүтээгдэхүүний ашиглалттай холбогдсон үйл ажиллагаа юм. *Эх сурвалж: (VocabDivtionary, n.d.)*

Угаалгын үйлчилгээний байгууллага: Хэрэглэгчдийн хувцас, ахуйн эд зүйлсийг цэвэрлэх, боловсруулах, хадгалах үйлчилгээг үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага. *Эх сурвалж: (Commercial Laundry Equipment, n.d.)*

Технологи:
Угаалгын үйлчилгээний үйл ажиллагаанд ашиглагдаж буй угаалгын машин, хатаагч, индүү, ариутгалын төхөөрөмж зэрэг техник хэрэгсэл болон эдгээрийг ашиглан үйлчилгээг чанартай, үр ашигтай гүйцэтгэх арга, процессын нэгдэл. *Эх сурвалж: (Insider, n.d.)*

Мэдээллийн сан:
Угаалгын үйлчилгээний байгууллагын хэрэглэгчийн мэдээлэл, захиалга, хүргэлтийн хаяг байршил, үйлчилгээний төрөл, үнэ тариф, ажиллах цагийн хуваарь, үйлчилгээний төлөв болон гүйцэтгэлийн талаарх өгөгдлийг цаашид өргөтгөх боломжтойгоор бүрдүүлсэн өгөгдлийн сан. *Эх сурвалж: (VocabDivtionary, n.d.)*

Захиалгын бүртгэлийн систем:
Хэрэглэгчийн өгсөн угаалгын захиалга, үйлчилгээний төрөл, авах болон хүргэх хугацаа, төлөв байдал, төлбөрийн мэдээллийг бүртгэх, хянах зориулалттай систем. *Эх сурвалж: (Laudon K. C., 2020)*

Ажлын байр:
Ажилтан угаалгын үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай угаалгын машин, хатаагч, индүү, ариутгалын төхөөрөмж, нэмэлт хэрэгслээр тоноглогдсон ажиллах орчин. *Эх сурвалж: (Wikipedia, n.d.)*

1.2 Угаалгын үйлчилгээ, түүний төрлүүд

1. Хувцас угаалгын үйлчилгээ

Энэ нь өдөр тутмын хувцсыг угаах, хатаах, индүүдэх үйлчилгээг хамарна. Хэрэглэгчид өөрсдийн хувцсыг өгч, тодорхой хугацааны дараа цэвэрлэгдсэн байдлаар буцаан авдаг. Зарим тохиолдолд жингээр эсвэл ширхэгээр үнэ тогтоодог. Зориулалттай хатаах процесс нь хувцасны хэмжээг багасгахгүй, хэлбэрийг алдагдуулахгүй байхаар зохицуулагдана. Энэхүү шатанд бохирдлыг арилгах, материалын чанарыг хадгалах, хэрэглэгчийн шаардлагад нийцсэн байдлаар хувцсыг бэлддэг *Эх сурвалж: (CoCo, n.d.)*

2. Хими цэвэрлэгээ

Хими цэвэрлэгээ нь ус ашиглахгүйгээр тусгай химийн бодис ашиглан хувцас, нэхмэл эдлэлийг цэвэрлэх арга юм. Энэ нь ихэвчлэн ноос, торго, хүрэм, пальто зэрэг нарийн материалтай хувцсанд тохиромжтой бөгөөд хэлбэр, чанарыг алдагдуулахгүй байх давуу талтай. *Эх сурвалж: (CoCo, n.d.)*

3. Хөнжил, хивс, том оврын эдлэлийн угаалга

Энэ төрлийн үйлчилгээ нь ахуйн том оврын бүтээгдэхүүн болох хөнжил, гудас, хивс зэрэг эд зүйлсийг тусгай тоног төхөөрөмж ашиглан угаах, ариутгах үйл ажиллагааг хамарна. Ихэвчлэн улирлын чанартай эрэлттэй байдаг. *Эх сурвалж: (CoCo, n.d.)*

4. Өөрөө угаах үйлчилгээ

Хэрэглэгч өөрөө угаалгын машин ашиглан хувцсаа угаах боломжтой үйлчилгээ юм. Гадаад орнуудад өргөн тархсан боловч Монголд харьцангуй бага хөгжсөн. *Эх сурвалж: (CoCo, n.d.)*

5. Захиалга, хүргэлттэй угаалгын үйлчилгээ

Энэ нь хэрэглэгчийн байршлаас хувцсыг авч, угааж цэвэрлэсний дараа буцаан хүргэж өгдөг үйлчилгээ юм. Орчин үед энэхүү үйлчилгээ нь хэрэглэгчдэд илүү тохиромжтой, цаг хэмнэх давуу талтай тул эрэлт нэмэгдэж байна. *Эх сурвалж: (CoCo, n.d.)*

6.Гутал пүүз угаах үйлчилгээ

Энэ нь гутал пүүз угаах зориулалтын төхөөрөмжинд хийж угааж ариутгаад хатаах үйл ажиллагаа юм. *Эх сурвалж: (CoCo, n.d.)*

7.Ариутгах үйлчилгээ

Хувцас, нэхмэл эдлэлд байгаа нян, бактерийг устгах нэмэлт боловсруулалт хийх үйл ажиллагаа. Ариутгал нь эрүүл ахуй, хэрэглэгчийн аюулгүй байдалд шууд нөлөөлдөг. *Эх сурвалж: (CoCo, n.d.)*

8. Үнэр оруулах үйлчилгээ

Хувцсанд таатай үнэр шингээх үйл явц. Энэ нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний нийт туршлагыг сайжруулдаг. *Эх сурвалж: (CoCo, n.d.)*

9.Толбо арилгах

Хүнд бохирдлыг тусгай аргаар цэвэрлэх үйл ажиллагаа. Энэ шатанд тусгай бодис, технологи ашиглан туйлын бохирдлыг арилгаж, хувцсыг анхны өнгө, чанартайгаар сэргээдэг. *Эх сурвалж: (CoCo, n.d.)*

10.Хими цэвэрлэгээ

Хими цэвэрлэгээ гэдэг нь ус ашигладаггүй, оронд нь тусгай химийн уусгагч ашиглан хувцас, нэхмэл эдлэлийг цэвэрлэх процесс юм. Энэ аргыг ихэвчлэн усанд угаавал гэмтэх, агших, өнгө алдах эрслэг материалд ашигладаг. *Эх сурвалж: (CoCo, n.d.)*

1.3 Угаалгын үйлчилгээний захиалга, хүргэлтийн систем

Угаалгын үйлчилгээний захиалга, хүргэлтийн систем гэдэг нь гар утасны программ болон интернэт зэрэг цахим хэрэгслээр дамжуулан хэрэглэгч угаалгын үйлчилгээ захиалах, хувцас угаалгаад хүргэлтээр авах болон хүргэх хаяг, цагийг сонгох, үйлчилгээний төрөл, үнэ, гүйцэтгэх хугацааны мэдээллийг харах, мөн цахим төлбөр хийсний дараа захиалгыг баталгаажуулах боломжийг олгодог дижитал систем юм. *Эх сурвалж: (Pickup and Delivery Laundry Service Applications, 2021)*

Орчин үед ийм төрлийн систем нь хэрэглэгчдэд угаалгын газарт биечлэн очих шаардлагагүйгээр, хүссэн цагтаа захиалга өгөх, хүргэлтийн явцыг хянах, үйлчилгээний төлөвийг харах боломжийг бүрдүүлдэг. Мөн уламжлалт аргаар үүсдэг дараалал, хүлээлтийг багасгаж, үйлчилгээ авах процессыг илүү хялбар, хурдан, үр ашигтай болгодог. *Эх сурвалж: (Pickup and Delivery Laundry Service Applications, 2021)*

Түүнчлэн энэхүү систем нь нэмэлт зардал багатай, 24 цагийн турш тасралтгүй ажиллах боломжтой бөгөөд хэрэглэгчийн туршлагыг сайжруулах, байгууллагын үйл ажиллагааг автоматжуулах, өгөгдөлд суурилсан удирдлагыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. *Эх сурвалж: (Pickup and Delivery Laundry Service Applications, 2021)*

1.3.1 Захиалгын удирдлагын систем

Order Management System (OMS) нь бизнесийн байгууллагуудад захиалгыг эхнээс нь төгсгөл хүртэл удирдах, хянах, автоматжуулах иж бүрэн систем юм. OMS нь хэрэглэгчийн захиалгыг хүлээн авах, баталгаажуулах, бараа бүтээгдэхүүнийг илгээх, төлбөрийг боловсруулах, хүргэлт, буцаалт хүртэлх бүх процессыг нэгтгэн төвлөрсөн байдлаар удирддаг. Энэхүү систем нь орчин үеийн цахим худалдаа, агуулахын менежмент, хүргэлтийн үйлчилгээнд өргөн хэрэглэгддэг *Эх сурвалж:(IBM, n.d.)*

1.3.1.1 Захиалгын удирдлагын систем-ийн зорилго

1. Захиалгын бүх процессыг төвлөрсөн системээр хянах
2. Захиалга, бараа материал, төлбөрийн мэдээллийг тодорхой, хурдан, найдвартай удирдах
3. Хэрэглэгчдэд цаг хэмнэх, найдвартай үйлчилгээ үзүүлэх
4. Борлуулалтын олон сувгаар ирсэн захиалгыг нэгтгэн удирдах
5. Бизнесийн агуулахын түвшин, бараа материалын байдалыг бодит хугацаанд харах боломжийг олгох *(IBM, n.d.)*

1.3.1.2 Захиалгын удирдлагын систем-ийн онолын процесс

1. Захиалга хүлээн авах: Хэрэглэгч өөрийн хүссэн бүтээгдэхүүнийг сонгон захиалга үүсгэнэ. Захиалга нь гар утас, вэб сайт, аппликейшн, POS, колл төв зэрэг олон сувгаар хийгдэж болно Эх сурвалж: *(ibm.com).*

2. Захиалгын баталгаажуулалт: Систем нь захиалгын мэдээллийг шалгаж, боломжтой эсэхийг баталгаажуулна. Энэ нь бараа материалын тоо хэмжээ, үнэ, төлбөрийн амжилттай байдал зэрэг хүчин зүйлсийг хамарна.

3. Бараа харах / хангамж баталгаажуулах: Систем нь хэрэглэгчийн хүссэн бараа байгаа эсэхийг шалгаж, нийлүүлэх боломжтой захиалгыг баталж өгдөг.

4. Гүйцэтгэл ба бараа илгээх: Бараа сонгогдож, савлагдаж, илгээгдэх шат. Энэ нь агуулахын нөхцөл, тээвэрлэлт, хүргэлтийн үйл ажиллагааг хамарна.

5.Төлбөр, санхүүгийн бүртгэл: Захиалгын төлбөрийг боловсруулах, баримт бичиг үүсгэх алхам. Энэ нь санхүүгийн менежменттэй холбоотой.

6.Хүргэлт: Бараа хэрэглэгчдэд хүрэх хүртэл статус хяналт, маршрутын удирдлага, хүргэлтийн мэдээллийг өгдөг.

7.Буцаалт ба үйлчилгээ: Хэрэглэгч барааг буцаах, солих шаардлагатай бол OMS нь буцаалтын процессыг удирдана Эх сурвалж:. *(IBM, n.d.)*

1.3.1.3 Захиалгын удирдлагын систем-ийн ач холбогдол

Order Management System (OMS)-ийн ач холбогдол нь захиалгын бүх процессыг төвлөрсөн системээр удирдах замаар алдаа, хоорондын зөрүүг бууруулдагт оршино. Мөн OMS нь бараа материал, агуулахын түвшинг бодит хугацаанд харах боломжийг олгож, олон сувгаар борлуулагдсан барааны захиалгыг нэгтгэн удирдаж, хурдан, найдвартай үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Үүний үр дүнд хэрэглэгчийн сэтгэл ханамж дээшилж, бизнесийн үр ашиг, өрсөлдөх чадвар нэмэгддэг. *Эх сурвалж: (IBM, n.d.)*

1.3.2 Угаалгын үйлчилгээний захиалга, хүргэлтийн процесс

1. Захиалга авах:Хэрэглэгч апп, вэб сайт, утас-аар үйлчилгээний захиалгыг өгдөг. Захиалга болон авах хаяг, хүргэж өгөх хаяг, үйлчилгээний төрөл, цагийг тогтоодог. *Эх сурвалж: (Laundre, n.d.)*

2. Хувцсыг авах: Сервисийн ажилтан гэр/байршил руу очиж, хэрэглэгчийн өгсөн хувцсыг авч, тэмдэглэж шошголно. *Эх сурвалж:(Laundre, n.d.)*

3. Тээвэрлэлт ба Ангилал:Хувцсыг угаалгын төв рүү тээвэрлэнэ. Тэнд авсан бүх хувцсыг өнгө, материал, үйлчилгээний төрөл-өөр ангилж бэлтгэнэ. *Эх сурвалж: (Laundre, n.d.)*

4. Угаах, Хатаах, Цэвэрлэх:Хэрэглэгчийн хүссэн угаах/хатаах/хими цэвэрлэгээ-г хийж, стандарт дагуу ариутгаж цэвэрлэнэ. *Эх сурвалж: (Laundre, n.d.)*

5. Чанарын хяналт:Угаасан хувцсыг өнгө, хэлбэр, толбо болон үнэрийн шалгалт хийж чанарын шаардлага хангасан эсэхийг хянаж гаргана. *Эх сурвалж:(Laundre, n.d.)*

6. Сав баглаа боодол:Чанар шалгалтанд тэнцсэн хувцсыг эвхэж, багцалж, хэрэглэгчид өгөхэд бэлэн болгоно. *Эх сурвалж:(Laundre, n.d.)*

7. Хүргэлт: Хүргэлтийн ажилтан цагийн тохиролцооноос хамааран цэвэр хувцсыг хүргэж өгнө. *Эх сурвалж: (Laundre, n.d.)*

8. Санал хүсэлт ба Үнэлгээ: Үйлчилгээ сайжруулах зорилгоор хэрэглэгчээс сэтгэгдэл, үнэлгээ авах алхам байдаг. *Эх сурвалж: (Laundre, n.d.)*

Дүгнэлт

Угаалгын үйлчилгээ нь зөвхөн хувцас, нэхмэл эдлэл угаах, хатаах, индүүдэх процесс биш, харин хэрэглэгчийн цаг хэмнэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах олон үе шаттай иж бүрэн процесс болохыг ойлгосон. Үүнд: захиалга авах, хувцсыг авах, ангилах, угаах, хатаах, чанарын хяналт, сав баглаа боодол, хүргэлт болон хэрэглэгчийн санал хүсэлт ба үнэлгээ ордог нь системийн гүйцэтгэл, үр ашигтай шууд холбоотой болохыг энэхүү онолын судалгааны хүрээнд ойлгосон.Мөн онлайн захиалга, хүргэлтийн систем нь хэрэглэгчдэд биечлэн очих шаардлагагүйгээр, хүссэн цагтаа захиалга өгөх, үйлчилгээний төлөвийг хянах боломж олгож, уламжлалт аргаар үүсдэг дараалал, хүлээлтийг багасгаж, үйлчилгээг илүү хурдан, найдвартай болгодог болохыг онцолж болно. Аливаа истем нь байгууллагын үйл ажиллагааг автоматжуулах, өгөгдөлд суурилсан удирдлагыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.Үүнээс дүгнэхэд, угаалгын үйлчилгээний захиалга, хүргэлтийн системийг оновчтой хөгжүүлэх нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, үйлчилгээний чанар, хурд, найдвартай байдлыг сайжруулахад шууд нөлөөлөх бөгөөд бизнесийн үр ашиг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай болохыг ойлгосон.

1.4 Сэдвийн судлагдсан байдал

Захиалгын систем нь үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хялбарчлах, хэрэглэгчдэд илүү тав тухтай, хурдан үйлчилгээ үзүүлэх зорилгоор үе шаттайгаар хөгжиж ирсэн. Анх хэрэглэгчид биечлэн очиж, бичгээр захиалга өгдөг байсан нь цаг

хугацаа их шаарддаг, алдаа гарах магадлал өндөртэй, үр ашиг багатай байсан.20-р зууны дунд үеэс эхлэн утас, факс ашиглан захиалга өгөх боломж бий болж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн боловч мэдээлэл хадгалах, удирдах тал дээр хязгаарлагдмал хэвээр байсан. 1980-аад оноос компьютер ашиглан захиалгын мэдээллийг бүртгэж, хадгалах боломж бүрдсэн нь байгууллагын үйл ажиллагааг илүү системтэй болгох эхлэл болсон.1990-ээд оноос интернет хөгжсөнөөр вэбсайт болон и-мэйл ашиглан захиалга авах боломж бий болж, хэрэглэгчид зайнаас үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн. 2000-аад оноос ухаалаг гар утасны аппликейшнүүд хөгжиж, захиалга өгөх үйл явц илүү хялбар, хүртээмжтэй болсон бөгөөд хэрэглэгчийн туршлагыг сайжруулахад чухал нөлөө үзүүлсэн.Сүүлийн жилүүдэд, ялангуяа 2020 оноос хойш хиймэл оюун ухаан (AI), интернэтэд холбогдсон төхөөрөмжүүд (IoT) зэрэг дэвшилтэт технологиуд нэвтэрснээр хэрэглэгчийн зан төлөв, хэрэгцээнд тулгуурласан ухаалаг захиалгын системүүд хөгжиж байна. *Эх сурвалж: (Dave Chaffey, 7th (2019))*

Угаалгын үйлчилгээний салбарт захиалга, хүргэлтийн системийг хөгжүүлэх нь хэрэглэгчийн цагийг хэмнэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, мөн байгууллагын үйл ажиллагааг илүү үр ашигтай, оновчтой удирдах боломжийг бүрдүүлдэг. Ялангуяа хүргэлтийн үйлчилгээтэй хосолсон онлайн захиалгын систем нь хэрэглэгчдэд угаалгын газарт биечлэн очих шаардлагагүйгээр үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж байна.Иймээс орчин үеийн дижитал технологийг ашигласан угаалгын үйлчилгээний захиалга, хүргэлтийн системийг хөгжүүлэх нь хэрэглэгч төвтэй, найдвартай, үр ашигтай үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоход чухал ач холбогдолтой юм *Эх сурвалж: (ResearchGate, n.d.)*

Хүснэгт 1.1 *Сэдвийн судлагдсан байдал*

№	Судалгааны нэр	Товч хураангуй

1	Information Technology for Management	Энэхүү номонд мэдээллийн технологи нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, автоматжуулах, үр ашиг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй болохыг судалсан бөгөөд үүний нэг хэсэг болгон онлайн системүүдийг, тэр дундаа захиалгын системийг бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нэвтрүүлж ашиглах боломжийг авч үзсэн байдаг. Тус судалгаанд онлайн захиалгын систем нь захиалга авах процессыг автоматжуулснаар гар ажиллагааг бууруулж, алдаа багасган, үйл ажиллагааг илүү хурдан, оновчтой болгодог гэж дүгнэсэн. Мөн хэрэглэгчид хүссэн үедээ буюу 24/7 үйлчилгээ авах боломжтой болсноор хэрэглэгчийн сэтгэл ханамж болон туршлага мэдэгдэхүйц сайжирдаг гэж үзсэн. Үүнээс гадна байгууллага захиалгын мэдээллийг хадгалж, боловсруулснаар хэрэглэгчийн зан төлөвийг ойлгож, илүү оновчтой шийдвэр гаргах боломж бүрддэг гэж тайлбарласан. Иймээс онлайн захиалгын системийг нэвтрүүлэх нь байгууллагын зардлыг бууруулж, цаг хугацаа хэмнэж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх стратегийн чухал хэрэгсэл болохыг онцолсон. *Эх сурвалж:(Laudon K. C., Management Information Systems, 2020)*
2	Digital Business and E-Commerce Management	Онлайн орчин дахь хэрэглэгчийн зан төлөв хэрхэн өөрчлөгдөж байгааг судалсан бөгөөд орчин үеийн хэрэглэгчид хурдан, хялбар, хүссэн үедээ ашиглах боломжтой үйлчилгээг илүүд үздэг болохыг онцолсон. Судалгаанд дижитал хэрэглэгчид мэдээллийг богино хугацаанд авах, шийдвэрийг хурдан гаргах хандлагатай болсон тул үйлчилгээний хурд, хүртээмж хамгийн чухал хүчин зүйл болсон гэж тайлбарласан. Мөн гар утасны хэрэглээ эрс нэмэгдэж, хэрэглэгчид ихэнх үйлчилгээг мобайл аппликейшнээр дамжуулан авах болсон нь бизнесүүдэд мобайл суурьтай шийдэл хөгжүүлэх шаардлагыг бий болгож байна гэж дүгнэсэн. Иймээс аппликейшн нь хэрэглэгчидтэй илүү ойр, илүү хурдан, илүү хувийн (personalized) харилцаа үүсгэх боломж олгодог тул орчин үеийн байгууллагуудад зайлшгүй хэрэгтэй хэрэгсэл болохыг онцолсон. *Эх сурвалж:(Chaffey, 2019)*
3	Last mile delivery: a literature review	Энэхүү судалгаанд e-commerce орчин дахь хүргэлтийн сүүлийн шат буюу “last-mile delivery” нь хэрэглэгчидтэй шууд холбогддог хамгийн чухал процесс болохыг авч үзсэн бөгөөд энэ шатанд гарсан алдаа, саатал нь нийт үйлчилгээний чанарт хамгийн их нөлөөлдөг гэж дүгнэсэн. Судалгаагаар хүргэлтийн хурд, найдвартай байдал, уян хатан байдал нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тодорхойлох гол хүчин зүйлс бөгөөд ялангуяа захиалгын явцыг бодит цаг хугацаанд хянах (real-time tracking) боломж нь хэрэглэгчдэд итгэл төрүүлж, үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлдэг болохыг онцолсон. Мөн хэрэглэгчид захиалгынхаа байршил, хүрэх хугацааг мэдэж байхыг илүүд үздэг тул tracking системгүй хүргэлтийн үйлчилгээ нь өрсөлдөх чадвар багатай гэж үзсэн. Иймээс хүргэлтийн системийг оновчтой зохион байгуулах, real-time

		tracking технологийг нэвтрүүлэх нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахад зайлшгүй чухал ач холбогдолтой гэж дүгнэсэн *Эх сурвалж: (Mangiaracina, 2019)*
4	Impact of lifestyle changes on service demand	Судалгаанд хотжилт болон орчин үеийн амьдралын хэв маягийн өөрчлөлт нь үйлчилгээний эрэлтэд хэрхэн нөлөөлж байгааг авч үзсэн бөгөөд хот суурин газар хүн амын нягтаршил нэмэгдэхийн хэрээр хүмүүсийн амьдралын хэмнэл хурдасч, цаг хугацаа хамгийн үнэ цэнтэй нөөц болж байгааг онцолсон. Судалгаагаар ажил эрхлэлт нэмэгдэх, завгүй амьдралын хэв маяг түгээмэл болохын хэрээр хүмүүс өдөр тутмын цаг их шаарддаг ажлуудыг (тухайлбал угаалга, цэвэрлэгээ зэрэг) өөрсдөө хийхээс илүү мэргэжлийн үйлчилгээ ашиглах хандлага эрс өсдөг гэж дүгнэсэн. Мөн хүргэлттэй болон захиалгат үйлчилгээ нь хэрэглэгчдэд илүү тохиромжтой, цаг хэмнэсэн шийдэл болж, хотын амьдралд зайлшгүй хэрэгцээтэй үйлчилгээ болон хөгжиж байгааг тайлбарласан. Иймээс угаалгын үйлчилгээ, тэр дундаа хүргэлттэй, онлайн захиалгатай хэлбэр нь орчин үеийн хотын хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн, эрэлт өндөртэй үйлчилгээ болохыг баталж байна *Эх сурвалж: (Yoon, 2018)*

Дүгнэлт

Мэдээллийн технологи, дижитал платформ, хэрэглэгчийн зан төлөв, хотжилтын нөлөө нь орчин үеийн үйлчилгээний салбар, угаалгын үйлчилгээ, захиалга болон хүргэлтийн системд томоохон өөрчлөлт авчирч байгааг харуулж байна. Судлаачид онлайн захиалгын систем нь байгууллагын үйл ажиллагааг автоматжуулж, зардлыг бууруулан, үр ашгийг нэмэгдүүлдэг болохыг онцолсон бол платформууд нь бизнесийг илүү уян хатан, хэрэглэгч төвтэй хэлбэрт шилжүүлж байгааг баталсан. Түүнчлэн Монголд үйлчилгээний салбарын өрсөлдөөн харьцангуй бага бөгөөд дижитал платформ, онлайн захиалгын системийг нэвтрүүлсэн байгууллага хэрэглэгчдэд илүү тухтай, цаг хэмнэх үйлчилгээ үзүүлж, өрсөлдөх давуу талтай болох боломжтой. Хотжилт, завгүй амьдралын хэв маяг, гар утасны хэрэглээ нэмэгдэж байгаатай уялдуулан, онлайн захиалга, мобайл аппликейшн, хүргэлтийн системийг нэгтгэсэн дижитал шийдэл нь Монголын хэрэглэгчдийн хэрэгцээг хангах, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж дүгнэж болно. Хэрэглэгчид хурдан, хялбар, хүссэн үедээ авах боломжтой үйлчилгээ, тэр дундаа website ,мобайл аппликейшн ашиглахыг илүүд үздэг нь захиалга болон хүргэлтийн системийг хөгжүүлэх шаардлагыг улам нэмэгдүүлж байна. Мөн бодит цагийн хяналт (real-time tracking) бүхий хүргэлтийн систем нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг

нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж, үйлчилгээний чанарыг тодорхойлогч элемент болдог. Иймээс онлайн захиалга, хүргэлтийн системийг нэгтгэсэн системийн шийдэл нь Монголын угаалгын үйлчилгээний салбарт хэрэглэгчийн хэрэгцээг хангах, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж дүгнэж болно.

Бүлгийн дүгнэлт

Энэхүү бүлэгт угаалгын үйлчилгээний захиалга хүргэлтийн системийг хөгжүүлэхэд шаардлагатай онолын суурь ойлголтуудыг судаллаа. Орчин үеийн салбар нь зөвхөн угаах үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй, төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг:

- Хувцас угаах
- Хими цэвэрлэгээ
- Хөнжил, хивс, том оврын эдлэлийн угаалга
- Өөрөө угаах үйлчилгээ
- Захиалга, хүргэлттэй угаалгын үйлчилгээ
- Гутал, пүүз угаах үйлчилгээ

Мөн дээрх шинжилгээнээс дүгнэхэд манай хүргэлтийн системд дараах үндсэн функцууд зайлшгүй байх ёстой

- Хэрэглэгчийн бүртгэл, нэвтрэлт – мэдээлэл аюулгүй хадгалах, OTP/нууц үгээр нэвтрэх
- Үйлчилгээний төрөл сонгох – өдөр тутмын угаалга, гар угаалга, хивс/хөнжил, өөртөө үйлчлэх, гутал угаах;
- Гэрээс авах / хүргэх үйлчилгээ – хүргэлтийн маршрутыг оновчтой төлөвлөх
- Захиалгын цаг сонгох – хүссэн цагтаа захиалга өгөх, хүргэлтийг төлөвлөх
- Онлайн төлбөр ба статус хянах – картаар, мобайл банк; захиалгын явц, хүргэлт real-time харах
- Мэдэгдэл (Notification) – Мэссэж, мэдэгдэл, email -аар мэдээлэх
- Хэрэглэгчийн үнэлгээ, санал – review, rating системээр сэтгэл ханамж хэмжих
- Pickup үед зураг баталгаажуулалт(Хүргэлтийн ажилтан хувцас авахдаа зураг авааД системд хадгална)

- Эд зүйлийн хөнцөл байдлын бүртгэл(Өнгө, материал, гэмтэл бүртгэнэ Толбо тэмдэглэнэ)
- Өмнөх / Дараах харьцуулалт(Угаахаас өмнө зураг болон угаасны дараа зураг)
- Цэвэрлэсэн үр дүнгийн тайлан

Захиалга, хүргэлтийн систем нь хэрэглэгчийн цаг хэмнэх, түргэн, хялбар үйлчилгээ авах эрэлтийг хангаж, үйлчилгээний чанар, хүртээмж, хэрэглэгчийн туршлагад эерэг нөлөө үзүүлдэг. Тиймээс энэхүү системд хүргэлт хийх боломжтой, захиалга бүрэн удирддаг модулиуд зайлшгүй шаардлагатай бөгөөд бүх үйлчилгээг бүрэн цогц багтаасаан байна.

II БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГА БА АСУУДЛЫН ШИНЖИЛГЭЭ

2.1 Компаний танилцуулга

LaundryZone Mongolia нь Монгол Улсад анх удаа өөртөө үйлчлэх угаалгын газрыг үүсгэн байгуулж, орчин үеийн автомат угаалга, хатаалга, арчилгааны үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хэрэглэгчдэд хүргэх зорилготой үйл ажиллагаа явуулдаг. Компани нь салбартаа анхдагч бөгөөд Монголын угаалгын үйлчилгээний салбарт тэргүүлэгч байр суурь эзэлдэг, инновацийн технологи болон өндөр чанартай үйлчилгээгээрээ алдартай.

Байгуллагын алсын хараа

Монголд угаалга, хатаалгын шинэ соёлыг түгээн, хэрэглэгч бүр цаг хугацаагаа хэмнэх, цэвэрхэн, тав тухтай амьдралын хэв маягийг эрхэмлэхэд туслах.

Эрхэм зорилго

- Түргэн шуурхай, чанартай үйлчилгээг үзүүлэх
- Орчин үеийн автомат тоног төхөөрөмжөөр үйлчлүүлэгчдийн цагийг хэмнэх
- Цэвэрлэгээ, ариун цэврийн олон улсын стандартыг хэрэгжүүлэх

Компаний давуу тал

- Өндөр хүчин чадалтай угаагч, хатаагч төхөөрөмжүүд
- Өөртөө үйлчлэх автомат систем, хэрэглэгч цагийн хуваарийн дагуу үйлчилгээг ашиглах боломж
- Орчин үеийн цахим төлбөрийн систем нь үйлчлүүлэгчдэд хялбар, хурдан, найдвартай төлбөр тооцооны боломжийг олгодог
- Туршлагатай, мэргэшсэн ажилтны баг өдөр бүр хэрэглэгчдэд хамгийн сайн үйлчилгээг үзүүлэхэд ажилладаг
- Олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ, Солонгосын технологи ашиглан дэлхийн стандартын үйлчилгээг санал болгодог
- Цэвэр, тав тухтай орчин, хүртээмжтэй үнэ, хүн бүрт боломжийн үнээр үйлчлэх бодлого

Статистик үзүүлэлт

- 50+ угаагч машин
- 50+ хатаагч машин
- 40+ гутал, пүүзний угаагч, хатаагч
- 100,000+ нийт хэрэглэгч

Компаний өсөлтийн түүх

Компани 2019 оны 9-р сарын 1-нд Дүнжингарав салбартаа үйл ажиллагаагаа анх эхлүүлсэн бөгөөд эхний шатанд нийт 12 машинтайгаар ажилласан. Энэ нь компанийн анхны туршилт, үйл ажиллагааны суурь болсон онцгой өдөр байв.2020 онд 4-р хороолол салбар нээгдсэнээр үйлчилгээгээ хотын захын хэрэглэгчдэд хүргэж, зах зээлийн боломжийг өргөжүүлсэн.2021 онд Яармаг болон Хүүхдийн-100 салбарууд нээгдсэн нь компанийн өргөн хүрээтэй хэрэглэгчийн сүлжээг бий болгож, үйлчилгээг төвлөрсөн болон орон нутгийн хэрэглэгчдэд хүргэх боломжийг нэмэгдүүлсэн.2022 онд Сансар-Имарт, Барс, Өмнөговь, 1-р хороолол салбарууд нээгдсэнээр үйлчилгээгээ улсын төв болон алслагдсан бүсэд хүргэх боломжтой болсон.2023 онд компани салбарын тоогоо ихээхэн өргөжүүлж, Эх нялхас-Зурагт, Эрдэнэт, Хөвсгөл-Мөрөн, Нарны хороолол, 10-р хороолол И-март гэх мэт салбаруудыг нээж, улс даяар үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Энэ нь компанийн үйлчилгээг хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй, түргэн шуурхай болгоход чиглэсэн стратегийн том алхам болсон бөгөөд одоогоор нийт 38 салартай амжилттай үйл ажиллагаагаа явуулж байна

Үйлчилгээний төрөл


- Өөртөө үйлчлэх угаалгын үйлчилгээ
- Хатаах үйлчилгээ
- Гутал, пүүзний угаалга
- Том оврын эдлэл, дэвсгэр, хивс угаалга

Дүгнэлт

LaundryZone нь Монголын хэрэглэгчдэд зориулсан орчин үеийн автомат угаалгын үйлчилгээ, тав тухтай орчныг хослуулсан салбарын тэргүүлэгч байгууллага юм. Өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж, өөртөө үйлчлэх систем, олон салбарын сүлжээ нь хэрэглэгчдэд үйлчилгээг хурдан, найдвартай хүргэх боломжийг олгож байна. Цахим төлбөрийн систем, мэргэшсэн ажилтны баг, олон улсын стандартын үйлчилгээгээрээ компанийн нэр хүнд, итгэлцлийг улам бататгасан

2.2 “LaundryZone Mongolia ”угаалгын үйлчилгээний AS-IS процесс

Зураг 2.1 *AS-IS process*



2.3 Асуудлын шинжилгээ

2.3.1 PIECES шинжилгээ

P-Performance - Гүйцэтгэлийг сайжруулах хэрэгцээ.

